

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2021.04.27

Цагаандэлгэр сум

№	Захирам жийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	A/21	Аймгийн аварга малчин өрх, аварга тэмээчин,аварг а тариаланч, шалгаруулах тухай 2021.01.13	11	Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодолго төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ- Очир), Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга(Б.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ХОХБТХ ХХААГ Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Тус сумаас аймгийн аварга малчин өрхөд 1 дүгээр багийн малчин Я.Батдорж, 2-р багийн малчин Ш.Эрдэнэсүх, 3-р багийн малчин У.Далхжав, 4-р багийн малчин Ч.Даваасүрэн нарыг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн багаас тодорхойлсныг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ХХААГазар материалыг хүргүүлсэн. Дээрх малчдын материалыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1-р багийн малчин Я.батдорж, 3-р багийн малчин Ц.Далхжав нар нь аймгийн аварга малчин өрхөөр тодорсон амжилт үзүүллээ.	100
2	A/27	Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2021.01.18	13	Хоёр. Тус захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) , сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	СТСХ МХГ Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2021 оныг аймгийн Засаг даргаас “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгосон зарласан. Үүнтэй холбогдуулан эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын эрх ашгийг хангах зорилгоор бүх төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ажилчдын цалин хөлсийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн сард хоёр удаа олгож хэвшүүлэхээр болсон. Энэхүү захирамжийн дагуу 2021 оны 01 дүгээр сараас эхлэн цалинг сар бүрийн 10-ны дотор урьдчилгаа маягаар давхардсан тоогоор 42 албан хаагчдад 11,660,000.00 төгрөгийн урьдчилгаа цалин олгосон байна. Төрийн албан хаагчдын сарын эцэст төлөх цалингийн зээл өндөр дүнгээр төлөгддөг тул хоёр хувааж авмааргүй байна гэсэн санал, хүсэлт ирж байна. Мөн цаашид цалинг хоёр хувааж олгоход орон нутгийн орлогын дансны үлдэгдэл бага, орлогын биелэлт муу, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт сар бүрийн 12-16-ны	30

						хооронд ордог зэргээс шалтгаалан сарын эхээр цалин тавих санхүүжилт дутмаг байна.	
3	A/56	Ажлын хэсэг байгуулах тухай 2021.02.15	23	3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумдын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг цаашид ашиглах эсэх талаар шийдвэрлэж тодорхой арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нар	Хуучин барилга байгууламжийг засварлуулах, шаардлага хангахгүй болсон барилгыг буулгуулах, барилгын хуучин хогийг цэвэрлүүлэх талаар арга хэмжээ авч 1 барилгыг ОНХС-ын хөрөнгөөр сэргээн засварлах, бусад хуучин барилга байгууламжийг холбогдох эздэд нь хугацаатай мэдэгдэл хүргүүлэхээр төлөвлөсөн.	30
4	A/69	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай 2021.02.24	29	2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааг үндэсний төлөвлөгөөний хүрээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), дархлаажуулах арга хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллагыг татан оролцуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (Ц.Лувсанжамц), Сумдын онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.	ЭМГ МХГ ЦГ ОБГ Сумдын онцгой комиссын дарга нар	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/18 дугаар захирамжаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан. 2021 оны 04 сарын 06-нд вакциатор Б.Мөнхтамир, хэсгийн цагдааг Э.Өлзий-Орших нар 53 хүн тун вакциныг аймгийн Эрүүл мэндийн газраас татан авчирсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дархлаажуулалтын түр цэгийг сумын соёлын төвд байгуулан тохижуулж бэлэн байдлыг ханган ажилласан. Эрүүл мэндийн төвийн дархлаажуулалтын багийн бүрэлдэхүүн 2021 оны 04 сарын 07-нд Коронавирусын эсрэг дархлаажуулалтын 1-р тунг 43 хүнд 81,13%-ийн хамрагдалттайгаар дуусгасан. Үүнээс жирэмсэн 4, эсрэг заалттай 3, эрүүл мэндийн шалтгааны улмаас хойшлуулсан 3 албан хаагч хамрагдаагүй.	100

5	A/93	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай 2021.03.09	36	2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж, Хяналт - шинжилгээний үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцон зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 25-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст тайлагнахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар	2020 оны сумын Засаг даргын Тамгын газар, харъяа төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2021.03.26-ны өдөр сум Засаг даргаар батлуулан хяналтандаа авч холбогдох байгууллага, албан хаагчдад хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарах асуудлуудын талаар чиглэл өгсөн.	70
6	A/110	Автомашины шатахуун зарцуулалтын нормыг шинэчлэн тогтоохыг зөвшөөрөх тухай 2021.03.19	50	3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Санхүүгийн хяналт, аудитын алба (Г.Зоригт), төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.	СТСХ СХДАА Төсвийн шууд захирагч нар	Тус суманд ЗДТГ, ЭМТ, ЕБС-ийн өмчид бүртгэлтэй нийт 5 авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны нормыг аймгийн Засаг даргын А/110 дугаар захирамжаар тогтоож өгсний дагуу ЗДТГ-т бүртгэлтэй 3 авто машиныг 100 км-т 20 литр шатахуун, ЕБС-ийн 1 автомашиныг 100 км-т 20 литр түлш, ЭМТ-ийн автомашиныг 100 км-т 15,6 литр шатахуун зарцуулахаар зарцуулахаар тооцоолж шатахууныг олгож тооцоог бодон нормын дагуу хэвийн ажиллаж байна.	100

7	A/119	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.03.29	59	3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ЭМГ Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Тус суманд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 2 шалган нэвтрүүлэх хяналтын цэгийг 24 цагаар 28 албан хаагчдыг 2 техник хэрэгсэлтэйгээр томилгоожуулан ажиллууллаа. 2 шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр 1036 иргэн, 588 тээврийн хэрэгсэл орсон, 842 иргэн, 549 тээврийн хэрэгсэл гарсан бүртгэлтэй байна. Шуурхай штабын жижүүр, хөдөлгөөнт эргүүлийн зүгээс шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд тогтмол хяналт тавьж ажилласан. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллаж байгаа албан хаагчид голомттой бүсээс ирсэн иргэдийн шинжилгээний хариуг шалган нэвтрүүлж сумын ЭМТ-өөс 10 иргэнд 13 удаагийн түргэвчилсэн шинжилгээ, 7 иргэнд 11 удаагийн PCR шинжилгээ авч аймгийн ЭМГ-т хүргүүлсэн байна. Мөн голомттой бүсээс ирсэн 2 иргэнийг тусгаарлан ажиглах байранд 7 хоног хянаж үргэжлүүлэн гэрийн ажиглалтанд 7 хоног хянасан. Мөн дам хавьтлын 51, ойрын хавьтлын 3, нийт 54 иргэнийг гэрийн ажиглалтанд 7 хоног байлгаж хяналт тавьж ажилласан байна. Сумын Засаг даргын 2021 оны 04 сарын 22-ны өдрийн А/28 дугаар захирамжаар тусгаарлах байрны бэлэн байдлыг хангуулах, тусгаарлан ажиглах байр болон эмчлэн хянах албан хаагчдыг бүрэлдэхүүн, ажил үүргийн хувиарыг батлан томилгоожуулсан.	100	
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ								75,7%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР